



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь хэсгийн заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 108,347,548.00 (нэг зуун найман сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун дөчин найм) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 419 дүгээр нээлттэй хорих ангид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга Б.Ичинхорлоо, Хэнтий аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, дэд хурандаа Д.Хатанбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулан бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

900119



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 04 дүгээр сарын 04-ны  
едрийн 430 тоот тогтоолын  
хавсралт

Хэнтий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 419 дүгээр нээлттэй хорих ангийн балансад  
шилжүүлэн бүртгэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон он	Хэм жих нэгж	тоо шир хэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөгөөр/	Хуримтлагдсан эзлэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/
1	Тоёото Ландкрузер-200 маркийн, УБЗ 04-67 улсын дугаартай, арлын дугаар- JTMDV09VXA4046931, суудлын автомашин	2010	ш	1	108,347,548.00	108,347,548.00	108,347,548.00	0.00
				1 (нэг)		108,347,548.00 (нэг зуун найман сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун дөчин найм)	108,347,548.00 (нэг зуун найман сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун дөчин найм)	